



**Н.НЯМДАВААГИЙН НЭРЭМЖИТ  
ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Г Жагсаалт, журам батлах тухай Г

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дугаар тогтоол тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хавдар судлалын үндэсний төвийн "Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Ажил үүргийн дагуу төлбөртэй хийгдэх тусламж, үйлчилгээний жагсаалт, норм"-ыг хоёрдугаар, "Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын хуваарилалт"-ыг гуравдугаар, "Эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г дөрөвдүгээр, "Тасгуудад ажиллуулах төлбөрт орны тоо"-г тавдугаар, "Төлбөртэй тусламж, үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй үйлчлүүлэгчийн хүсэлтийн хуудас"-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй байхаар зохион байгуулж, ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгчид нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (С.Хүрэлсүх), үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Ц.Уранчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг улирал тутамд танилцуулахыг дотоод аудитор (Х.Гансүх)-д, төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг улирал тутам тооцож, ажиллахыг санхүү эдийн засгийн албаны дарга (Б.Дэнсмаа)-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцон, энэхүү тушаалыг 2022 оны 07 дугаар сарын 22-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЭРДЭНЭХҮҮ





Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төвийн  
ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн  
А/51 дүгээр тушаалын Нэгдүгээр хавсралт

### Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам

Гарчиг :	Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам
Анх боловсруулсан: Д. Лхагвасүрэн	Анх боловсруулсан огноо, акт : 2011.03.23, А/37, А/38
Өөрчлөлт оруулсан : Д.Лхагвасүрэн	Өөрчлөлт оруулсан огноо, акт: 2015.04.08, А/21
Өөрчлөлт оруулсан: Б.Дэнсмаа	Өөрчлөлт оруулсан огноо, акт: 2017.06.14, А/27
Өөрчлөлт оруулсан: Б.Дэнсмаа	Өөрчлөлт оруулсан огноо, акт: 2018.08.08, А/48
Өөрчлөлт оруулсан: Б.Дэнсмаа	Өөрчлөлт оруулсан огноо, акт: 2019.05.01, А/25
Өөрчлөлт оруулсан: Б.Дэнсмаа	Өөрчлөлт оруулсан огноо, акт: 2020.05.11
Өөрчлөлт оруулсан: Б.Дэнсмаа	Өөрчлөлт оруулсан огноо, акт: 2022.07.22
Баталгаажуулсан: Н. Эрдэнэхүү	Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Эрх зүй:	Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1,9, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/А/118, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 тоот тогтоол
Хавсралтын тоо:	Нийт хуудас: 16

## ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар Хавдар судлалын үндэсний төв /цаашид ХСҮТ гэх/-өөс үзүүлэх улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгч (иргэн, аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллага)-ийн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орсон тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлэх тохиолдолд эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг санал болгож, хэрэв татгалзсан тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу баталсан төлбөрийн хэмжээг баримтлан төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 1.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээ гэдэгт Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ, улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй, үйлчлүүлэгчийн хүсэлтээр эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх энэхүү тушаалын хавсралтад заасан тусламж, үйлчилгээ хамаарна.
- 1.4 Төвийн эмч, мэргэжилтнүүд болон ажилчид төлбөртэй үйлчилгээ авах тохиолдолд 50 хувийн хөнгөлөлт эдэлнэ.
- 1.5 “Эрүүл мэндийн байгууллагын ажилтан”, “Эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтны” үнэмлэхийг тус тус үндэслэн, төвийн цахим бүртгэлд бүртгүүлэхдээ “Эмнэлгийн мэргэжилтэн” гэсэн тэмдэглэгээг карт болон яаралтай тусламжийн хуудсанд бичиж шаардлагатай кабинетад дараалал харгалзахгүй үйлчлүүлнэ.

### ХОЁР. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 Төлбөртэй үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон үнийн жишгийг үйлчлүүлэгчдэд мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын цахим хуудсанд байрлуулна.
- 2.2 Үйлчлүүлэгчийг байгууллагын кассаар эсвэл цахимаар төлбөр төлөх бүхий л төрлийн боломжоор хангаж төлбөрийг төрийн сан дахь төсвийн үндсэн үйл ажиллагааны дансанд төвлөрүүлнэ.
- 2.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана.
- 2.4 Иргэнд төлбөр төлсөн баримт “и-баримт”-ыг заавал олгох бөгөөд төвийн нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.
- 2.5 Энэ журамд заасан төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогын зарцуулалтын жилийн эцсийн тайланг дараа жилийн төсвийн төсөлтэй хамт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

- 2.6 Үйлчлүүлэгч өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэлх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр буцаан олгож, баримтжуулна.
- 2.7 Эрүүл мэндийн байгууллага төлбөртэй тусламж, үйлчилгээг үзүүлэхэд байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй, мөн үйлчлүүлэгчдэд хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулах арга хэмжээг авна.
- 2.8 Лавлагаа лабораторид хийлгэх эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх лабораторийн тусламж, үйлчилгээний гадаад хяналтыг багцын тарифыг энэхүү тушаалын хавсралтаар баталсан шинжилгээ бүрийн төлбөрийн жишиг хэмжээг баримтлан байгууллага хоорондын гэрээгээр зохицуулна.
- 2.9 Тус төвийн зарим тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа зөвлөх эмч, эмч, сувилагч, бусад ажилтнууд гэрээнд тусгайлан заасан ажил үүргээс илүү нэмэлтээр хийсэн төлбөртэй үйлчилгээг энэхүү журмын гуравдугаар хавсралтын хуваарилалтын дагуу тооцно.
- 2.10 Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлсэн эмч, ажиллагсдад илүү цагийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.
- 2.11 Сар бүрийн 5-ны дотор төлбөртэй тусламж, үйлчилгээний хуваарилагдах боломжтой орлогыг тасаг, албаны хурлын протоколыг үндэслэн орлогыг Санхүү эдийн засгийн алба нарийвчлан гаргаж, төвийн Ерөнхий захирал сар бүрийн 10-ны дотор хянаж батална.
- 2.12 Энэхүү тушаалын 2.11 дахь заалтад заасан үйл ажиллагааны зардлыг зарцуулах нарийвчилсан журмыг төвийн Ерөнхий захирлаар батлуулан мөрдөж болно.

#### **ГУРАВ. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

- 3.1 Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг төлбөртэй тусламж, үйлчилгээнээс хөнгөлөх нөхцөл болон санхүүгийн дэмжлэг, туслалцаа авах бусад боломжийн талаар ил тод мэдээллээр хангаж, үйлчлүүлэгчийг албан бус төлбөр төлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 3.2 Эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын цахим хуудсанд байрлуулна. Үүнд:
  - 3.2.1 Санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ;
  - 3.2.2 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх болон даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ;
  - 3.2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зарим өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний жагсаалт, эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх болон даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ

#### **ДӨРӨВ. НӨХЦӨЛ САЙЖРУУЛСАН ТӨЛБӨРТЭЙ ӨРӨӨ АЖИЛЛУУЛАХ**

- 4.1 Төлбөрт орны тоо нь төвийн батлагдсан нийт орны 15%-иас илүүгүй байна.
- 4.2 Төлбөртэй орны төлбөрийг төвийн кассад тушаасан байна.
- 4.3 Төвийн кассаар тушаагдсан төлбөрт орны орлогыг төлөвлөгөөний биелэлтийн дагуу тулган, шалгаж хяналт тавина.
- 4.4 Төвийн дотоод журмыг зөрчсөн эмчлүүлэгчдэд төлбөрийг буцаан олгохгүй.
- 4.5 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.
- 4.6 Төвийн ажилчид болон тэдгээрийн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд төлбөрөөс хөнгөлүүлэх өргөдлийг нотлох баримтын хамт тухайн тасаг, нэгжийг хариуцсан тасгийн эрхлэгчээр баталгаажсанаар төлбөрийг 100 хувь хөнгөлнө.
- 4.7 Төлбөртэй өрөө ажиллуулсан тасагт олгогдох тасгийн хуримтлалын зарцуулалтыг тухайн тасгийн үйл ажиллагаанд зарцуулахаар төсөв гаргаж зарцуулна.
- 4.8 Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж орсон орлого нь тухайн эрүүл мэндийн байгууллагын жилийн нийт төсвийн 5 хувиас ихгүй байна.

#### **ТАВ. САХИУРЫН ОР-САНДЛЫГ АЖИЛЛУУЛАХ**

- 5.1 Сахиурын ор-сандлыг хөтөч, өлгүүрчин хариуцан ажиллаж, бүртгэлийн дэвтэр хөтөлнө.
- 5.2 Сахиурын ор-сандлыг үйлчлүүлэгч төлбөр төлсний дараа хөтөч, өлгүүрчнээс 12:00-16:00 цагийн хооронд хүлээн авах ба хүлээлгэн өгөх өдрийн 12:00 цагаас өмнө өгнө.
- 5.3 Үйлчлүүлэгч сахиурын ор-сандад хүлээн авахдаа өөрийн цахим үнэмлэх эсвэл гадаад паспортыг хөтөч, өлгүүрчинд хүлээлгэн өгч, бүртгэлийн дэвтэрт хүлээлгэн өгсөн болон авсан гарын үсэг зурна.
- 5.4 Хөтөч, өлгүүрчин нь сахиурын ор-сандлыг хүлээлгэн өгөх, хүлээн авахдаа бүрэн бүтэн байдлыг шалгах.
- 5.5 Үйлчлүүлэгч сахиурын ор-сандлыг хэрэглэж байх хугацаанд эвдсэн, бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдолд учирсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.

#### **ЗУРГАА. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, БУСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

- 6.1 Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг Амбулаторийн тасаг хариуцан зохион байгуулна.
- 6.2 Урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн бусад үйлчилгээг авах аж ахуйн нэгж байгууллага нь захиалгаа Санхүү, эдийн засгийн албанд өгч гэрээ байгуулж, баталсан хуваарийн дагуу үзлэг, тусламж, үйлчилгээ хийлгэнэ.
- 6.3 Урьдчилан сэргийлэх үзлэгт ажиллах эмч, ажилчдын хуваарийг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал батална.
- 6.4 Урьдчилан сэргийлэх үзлэгийг захиалагч байгууллагын хүсэлтийг харгалзан тухайн байгууллагад болон төвийн байранд хийнэ.
- 6.5 Байгууллагын хүсэлтээр хавдраас урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг 100-аас дээш хүн хамрагдсан тохиолдолд ажлын байран дээр нь очиж мэдээлэл өгнө.
- 6.6 Аж ахуй нэгж байгууллага нь гэрээнд заасан төлбөр 50,000,000-100,000,000 төгрөг бол 5 хувь, 100,000,000 төгрөгөөс дээш бол 10 хувь хөнгөлөгдөнө.

- 6.7 Аж ахуй нэгж байгууллага нь гэрээнд заасны дагуу төлбөрийг 100% төлж болох ба 80%-ийг үзлэгийн өмнө төрийн сан дах төвийн төсвийн харилцах дансанд шилжүүлсэн байх ба үзлэг дууссанаас хойш тайланг үндэслэн гүйцэтгэлээр төлбөрийг дуусгана.
- 6.8 Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан аливаа арга хэмжээ, өдөрлөгүүд, дэлхийн болон нийгмийн эрүүл мэндийн аливаа тэмдэглэлт өдрөөр зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийн бэлгийн картад 10 хүртэлх хувийн хөнгөлөлт олгож болно.

#### **ДОЛОО. НЭМЭЛТ ҮЗЛЭГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

- 7.1 Төвийн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэн нарын зөвшөөрлөөр ажлын байранд бусад эрүүл мэндийн байгууллагаас өөрийн хүсэлтээр мэргэжлээрээ дагалдах эмч, ажилтнуудыг дагалдуулж болно. Дадлагажих өдрүүдэд ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй.

#### **НАЙМ. КОРОНАВИРУС ХАЛДВАР (КОВИД-19) –ЫН ТЕСТ ӨГӨХ**

- 8.1 Коронавируст халдвар (Ковид-19)-ыг шүлсээр, хамраар оношлох тестийг иргэний хүсэлтээр төлбөртэй авна.
- 8.2 Коронавируст халдвар (Ковид-19)-ыг шүлсээр, хамраар оношлох тестийн үйлчилгээний орлогыг төвийн кассанд төвлөрүүлнэ.
- 8.3 Коронавируст халдвар (Ковид-19)-ыг шүлсээр, хамраар оношлох тестийн хийсэн төлбөрийг байгууллагын төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, холбогдох гарсан зардал, ажилласан эмч эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны цалин, нэмэгдэл цалин хөлс, урамшуулалд зарцуулна.

#### **ЕС. ХОРИГЛОХ ЗҮЙЛ**

- 9.1 Энэхүү тушаалын Дөрөвдүгээр хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх.
- 9.2 Эрүүл мэндийн байгууллагын ажлын үндсэн үйлчилгээнд багтан үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээг ажлын бус цагаар эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх.
- 9.3 Үйлчлүүлэгчээс эрүүл мэндийн байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах.
- 9.4 ЭМД-ын сангаас оношилгоо, шинжилгээнд олгож буй зардлыг даатгуулагчаас давхардуулан авахыг хориглоно.
- 9.5 Үйлчлүүлэгчдээс жагсаалтад зааснаас бусад тусламж, үйлчилгээнд төлбөр авах, эмч, мэргэжилтнүүд иргэдтэй шууд төлбөр тооцоо хийх.
- 9.6 Ажлын байрандаа эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, биологийн идэвхт бодис худалдаалах.
- 9.7 Энэхүү тушаалын хавсралтуудад заагдсан тусламж, үйлчилгээнээс төлбөр авахыг хориглоно. Үүнд : Бие засах газар, нөмрөг, улавч, хувцас өлгөх, шинжилгээний хариу өгөх зэрэг нийтлэг үйлчилгээ хамаарна. Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг эмнэлэгт үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй.
- 9.8 Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр үйлчлүүлэгч бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчээс илүү эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, асаргаа, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.

#### **АРАВ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ**

- 10.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ нь төвийн үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг төвийн Ерөнхий захирал хүлээнэ.
- 10.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд тус төвийн дотоод аудитор улирал бүр, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргана.
- 10.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтын талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг байгууллагын дарга, захирал нар хангаж ажиллана.

#### **АРВАН НЭГ. ЖУРАМ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

- 11.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 11.2 Эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.
- 11.3 Энэ журмын 11.2-т зааснаар иргэний төлбөрийг барагдуулсан бол Захиргааны ерөнхий хуулийн 109 дугаар зүйлд зааснаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.



Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төвийн  
ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн  
А/51 дүгээр тушаалын Хоёрдугаар хавсралт

**Ажил үүргийн дагуу төлбөртэй хийгдэх тусламж,  
үйлчилгээний жагсаалт, норм**

№	Тасаг, нэгжийн нэр	Тусламж үйлчилгээний нэр	Нэг өдрийн норм	Долоо хоногийн норм
1	Туяа эмчилгээний тасаг	Туяа эмчилгээ нэг байрлал /Остеоартроз/	10	47
2	Мэс заслын тасгууд	Хавдрын бус мэс засал, ажилбар	10	47
3	Өвдөлт намдаах эмчилгээ	Нурууны өвдөлт намдаах - 1021	5 /сард/	
		Өвдөгний өвдөлт намдаах / хос/ - 1024	44 /сард/	
		Өвдөгний өвдөлт намдаах /нэг/ - 1035	44 /сард/	
		Өвдөгний шингэн хийх тарилга	22 /сард/	

Жич: Сарын нормыг 22 өдрөөр тооцсон



Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төвийн  
ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн  
А/51 дүгээр тушаалын Гуравдугаар хавсралт

**Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын хуваарилалт**

№	Төрөл	Хуваарилалт /%/	
		Байгууллагын үйл ажиллагаанд	Эмч, ажилчдын урамшуулалд
1	Туяа эмчилгээ /Остеоартроз/	60	40
1.1	Эмч, ажиллагсдад		40
2	Сувилахуйн тусламж	50	50
3	Эмгэг судлалын шинжилгээ	80	20
3.1	Эмч, ажиллагсдад		20
4	Мэс ажилбар, мэс засал	70	30
4.1	Эмч, ажиллагсдад		30
5	Гэрээт үйлчилгээ /Ариутгал, Эмгэг судлалын шинжилгээ/	55	45
5.1	Эмч, ажиллагсдад		45
6	Мэргэжлийн эмч, мэргэжилтэн нарыг өөрийн хүсэлтээр ажлын байранд дадлагажуулагч	50	50
7	Коронавирус халдвар (Ковид-19) оношлох тест	98	2
7.1	Эмч, ажиллагсдад		2
8	Сахиурын ор-сандагч	80	20
8.1	Өлгүүрчин		20
9	Төлбөртэй өрөө	30	70
9.1	Эмч, ажиллагсдад		40
9.2	Тасгийн хуримтлалд		30

Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төвийн  
ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн  
А/51 дугаар тушаалын Дөрөвдүгээр хавсралт

**Эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	ЭМД-ын багцад хамаарах эсэх	Төлбөрийн жишиг хэмжээ
587	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Багажийн шинжилгээ	12 сувгын холтер зүрхний цахилгаан бичлэг	10201001	Үгүй	80,000
588	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Багажийн шинжилгээ	7 хоногийн холтер зүрхний цахилгаан бичлэг	10201002	Үгүй	600,000
592	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Багажийн шинжилгээ	Налуу ширээний зүрхний цахилгаан бичлэг	10201006	Үгүй	70,000
597	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Бүх төрлийн уян дурангийн оношилгоо	Дурангийн хэт авиан оношилгоо( EUS)	10202001	Үгүй	550,000
598	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Бүх төрлийн уян дурангийн оношилгоо	Унтуулгатай уян дуран ( Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх)	10202002	Үгүй	100,000
633	Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ	Тархины цахилгаан бичлэг	24 цагийн тархины цахилгаан видео бичлэг	10218003	Үгүй	300,000
652	Цөмийн анагаах ухааны тусламж, үйлчилгээ	Бамбайн булчирхайн эмгэгийн эмчилгээ, хяналт	Бамбайн олон зангилаат бахууг эмчлэх	10301001	Үгүй	250,000
654	Цөмийн анагаах ухааны тусламж, үйлчилгээ	Бамбайн булчирхайн эмгэгийн эмчилгээ, хяналт	Бамбайн хордлогот бахууг Иод-131-ээр эмчлэх	10301003	Үгүй	200,000
704	Сэтгэц, зан үйлийн эмгэгийн тусламж, үйлчилгээ	Сэтгэл заслын тусламж, үйлчилгээ	Бүх төрлийн сэтгэл засал( ганцаарчилсан, гэр бүлийн, хосын, өөрийгөө удирдах дасгал)	10801001	Үгүй	50,000

722	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн туслаж, үйлчилгээ	11101001	Үгүй	Гэрээний үнийн дүнгээр
724	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	11101003	Үгүй	80,000
725	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Гэр бүл болох, ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	11101004	Үгүй	80,000
726	Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө	Жолооны үнэмлэх авах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах	11101005	Үгүй	50,000
728	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Арьсны хоргүй хавдар, үү, ургацаг авах /байрлал хэмжээнээс хамаарч олон тооны жижиг хэмжээтэй бол/	11201002	Үгүй	80,000
730	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Ботокс эмчилгээ ( А хэлбэрийн Ботулины токсин)	11201004	Үгүй	300,000
732	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Даавар ( Тууралтан дотор хийх дааврууд)	11201006	Үгүй	30,000
733	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Доод зовхины гадагш шамралтыг засах	11201007	Үгүй	150,000
734	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Доод зовхины гадагш шамралтыг засах /Хөгшрөлтийн болон бусад шалтгаант /	11201008	Үгүй	250,000

735	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Доод зовхины урвалт засах	11201009	Үгүй	50,000
736	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Доод зовхины урвалтын дахилтыг засах	11201010	Үгүй	150,000
738	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Наснаас хамааралтай дээд зовхины арьсны илүүдэл авах /блефаро-халазис/	11201012	Үгүй	150,000
741	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Нүдний салстын нөхөөс хийх мэс засал	11201015	Үгүй	150,000
748	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Сэтэрхий чих оёх /2 тал /	11201022	Үгүй	45,000
749	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Том хэмжээтэй үү, ургацаг авах	11201023	Үгүй	10,000
751	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Халдварт нялаахай /гараар түүх/	11201025	Үгүй	20,000
756	Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ	Чихний дэлдэн засах /1 тал/	11201030	Үгүй	120,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Хамрын үзүүр засах	11201036	Үгүй	800,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Хамрын яс засах	11201036	Үгүй	1,000,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Нүүр өргөх	11201036	Үгүй	3,000,000

		үйлчилгээ				
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Нүүрний дунд хэсгийг өргөх	11201036	Үгүй	2,500,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Чамархайн өргөлт	11201036	Үгүй	500,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Дух өргөх	11201036	Үгүй	2,000,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Чих дэлдийлгэх	11201036	Үгүй	600,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - зажилуурын булчин багасгах	11201036	Үгүй	400,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Хацрын өөх багасгах	11201036	Үгүй	400,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Хацрын хонхорхой гаргах	11201036	Үгүй	400,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Сорви засах	11201036	Үгүй	200,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Харвин тайрах	11201036	Үгүй	4,300,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Хөхийг имплантаар томруулах	11201036	Үгүй	7,500,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Гоо сайхны нөхөн сэргээх мэс засал - Хөх сойх	11201036	Үгүй	3,500,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Остеоартроз, остеома, хондрома /1 удаа, 1 талбай/	11201036	Үгүй	10,000

762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Остеоартроз, остеома, хондрома /1 удаа, 2 талбай/	11201036	Үгүй	20,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ- Толгойны өвдөлт, тархины цус харвалт намдаах	11201036	Үгүй	30,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ- мигрений ботулизм токсин эмчилгээ	11201036	Үгүй	200,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ- Гурвалсан мэдрэлийн өвдөлтийн эмчилгээ хориг	11201036	Үгүй	50,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ - Бүх эрхтэний өвдөлт намдаах	11201036	Үгүй	40,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ- Хүзүү сээр, нуруу орчмын өвдөлт намдаах	11201036	Үгүй	90,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ - Үе мөчний хориг	11201036	Үгүй	50,000
762	Бусад тусламж, үйлчилгээ	ЭМД-ын багцад хамрагдаагүй бусад тусламж үйлчилгээ	Өвдөлт намдаах эмчилгээ- Бусад хориг	11201036	Үгүй	90,000

**Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад  
эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд  
үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
764	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-B титр	2010 5002	30,000
765	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	anti-D титр	2010 5003	30,000
766	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Кумбсын шууд бус урвалын шинжилгээ	2010 5004	23,000
767	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Кумбсын шууд урвалын шинжилгээ	2010 5005	23,000
768	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Резусын дэд бүлэг тодорхойлох	2010 5006	30,000
773	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны бүлэг, резус	2010 5011	8,000
777	Лабораторийн шинжилгээ	Иммуно гематологийн шинжилгээ	Цусны хувийн тохироо /Хуруу шилний аргаар/	2010 5015	39,000
782	Эмгэг судлалын шинжилгээ	Дархлаа гистохимийн (Иммуногистохими) ялган оношилгоо хийж, дүгнэлт өгөх	Иммуногистохимийн шинжилгээ хийх ( 1 маркерийн үнэлгээ)	2030 1001	131,000
784	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх ( зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд)	2030 3001	40,000
785	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх (ясны эд)	2030 3002	66,000
786	Эмгэг судлалын шинжилгээ	Амьд сорьцид оношилгооны эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	2030 3003	106,000
787	Эмгэг судлалын шинжилгээ	Мэс заслын дараах эдийн шинжилгээ хийж, онош тавьж, дүгнэлт өгөх	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх ( мэс ажилбараар авсан эд)	2030 4001	79,000
788	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Арьсны эдийн шинжилгээ авах, шууд тархан туяарах будгийн аргаар эдийг бэлтгэх	2030 5001	60,000
789	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Иммуногистохимийн шинжилгээ хийх	2030 5002	150,000
790	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх FNA	2030 5003	50,000
791	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Үений шингэний шинжилгээ	2030 5004	33,000

792	Эмгэг судлалын шинжилгээ	Эмнэлзүйн эс судлалын шинжилгээ	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторид шинжлэх (эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	2030 5005	48,000
-----	--------------------------	---------------------------------	--	--------------	--------

**Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх нэмэлт үйлчилгээний жагсаалт**

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
867	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэл /м2/	31401001	450
869	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	ЭМБ-ын тусгай хог хаягдал цуглуулах устгах (кг)	31401003	20,000
870	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй ерөөний үйлчилгээ (люкс)	31401004	60,000
871	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй ерөөний үйлчилгээ (хагас люкс 1)	31401005	30,000
			Эмнэлгийн төлбөртэй ерөөний үйлчилгээ (хагас люкс 2)		20,000
			Эмнэлгийн төлбөртэй ерөөний үйлчилгээ (хагас люкс 3)		10,000
872	Нэмэлт үйлчилгээ	Шарил хадгалах үйлчилгээ	Шарил хадгалах үйлчилгээ (нэг хоног, эмнэлгийн нас баралтаас бусад тохиолдолд)	31402001	28,000
873	Нэмэлт үйлчилгээ	Шарил тээвэрлэх үйлчилгээ	Шарил тээвэрлэх үйлчилгээ (1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд)	31402002	3,000
874	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат ариутгал	Бикс, боодол ( том, дунд, жижиг)	31404001	15,000
875	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат ариутгал	Дезкамер ( матрас, гудас, хөнжил, дэр, гадар даавуу)	31404002	4,500
876	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат ариутгал	ширхэгээр, дотуур хувцас	31405001	4,000
877	Нэмэлт үйлчилгээ	Өвчтөн тээвэрлэх	Захиалгаар өвчтөн тээвэрлэх 1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд	31406001	2,000

Төвөөс үзүүлэх бусад төлбөртэй тусламж, үйлчилгээ

№	Тусламж, үйлчилгээний нэр	Жишиг үнэ /төг/
1	ЭМД-гүй гадаадын иргэнд хийгдсэн үзлэг, оношилгоо, эмчилгээ	ЭМДҮЗ-ийн 01-р тогтоол нийт төлбөр *1.6
2	Ариутгал, Эмгэг судлал оношилгоо, шинжилгээ	Гэрээний үнийн дүнгээр
3	Мэргэжлийн эмч, мэргэжилтэн нарыг өөрийн хүсэлтээр ажлын байранд дагалдах	30,000/нэг өдрийн/
4	Коронавирус халдвар (Ковид-19) хамраар оношлох тест	25,000
5	Коронавирус халдвар (Ковид-19) шүлсээр оношлох тест	45,000
6	Хурлын заалны түрээс ( 1 цаг )	60,000
	Сахиурын ор - сандал	1 хоног
		3,500



Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төвийн  
ерөнхий захирлын 2022 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн  
А/51 дугаар тушаалын Тавдугаар хавсралт

**Тасгуудад ажиллуулах төлбөрт орны тоо**

№	Тасаг, нэгжийн нэр	Орны тоо	Платны дугаар	Өрөөний зэрэглэл
1	Ерөнхий мэс заслын тасаг	2	А7	Хагас люкс 1-р зэрэглэл
2	Элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасаг	2	5	Хагас люкс 1-р зэрэглэл
3	Цээжний хөндийн мэс заслын тасаг	2	Б4,	Хагас люкс 1-р зэрэглэл
4	Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг	2	6,	Хагас люкс 1-р зэрэглэл
5	Толгой хүзүүний мэс заслын тасаг	2	2,	ХС-2-р зэрэглэл
6	Туяа эмчилгээний тасаг	6	А3, Б 4, Б11	Хагас люкс 1-р зэрэглэл ХЛ-2-р зэрэглэл
7	Хими эмчилгээний тасаг	4	3, 6,	ХЛ-2-р зэрэглэл
8	Хими эмчилгээний тасаг – Өдрийн эмчилгээ	8		ХЛ-2-р зэрэглэл
9	Хөнгөвчлөх эмчилгээний тасаг	4	3, 6, 5,	ХЛ-3-р зэрэглэл ХЛ-3-р зэрэглэл ХЛ-2-р зэрэглэл
10	Ангиографийн тасаг	4	6,7	Хагас люкс 1-р зэрэглэл
11	Хөхний төв	4	3	Люкс
<b>НИЙТ ОРНЫ ТОО</b>		<b>40</b>		

